



МОНГОЛ УЛС
ДУНГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/367

Мандалговь

Газар эзэмших зориулалт
өөрчлөх тухай


Монгол улсын "Газрын тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3.1.5 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 6 дугаар багийн нутаг дэвсгэрт /Хуучин НИК ШТС-ын замын зүүн талд/ байршилтай "Дашваанжил" ХХК /РД:2025191/-ны ахуйн хэрэгцээний шингэрүүлсэн шатдаг хийн хангамжийн зориулалттай 5000 м²/0.5 га/ газрын зориулалтыг өөрчилж, автомашин болон ахуйн баллон хийгээр цэнэглэх станцын зориулалттай болгож, 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх аж ахуй нэгжтэй газар эзэмших гэрээ, гэрчилгээг шинэчлэн байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2015 оны А/434 дугаар захирамж, "Дашваанжил" ХХК-д холбогдох хэсэг, газар эзэмших /000310108/ тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0000985

